

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БОЛОН ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 11
ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	7-32
	1. Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ/	7-11
	2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ/	11-30
	3. Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ/	30-32

ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн нариуулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, шинжээч Х.Сүрэнхорол, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Э.Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга Д.Ганзориг, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Мэдээллийн холбооны операторуудын ассоциацын гүйцэтгэх захирал У.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Б.Хонгорзул, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт Б.Золбоо нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ш.Раднаасэд, Н.Алтанхуяг, Д.Ганбат, Б.Энх-Амгалан, Ц.Мөнх-Оргил, Т.Доржханд нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Э.Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д “нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай

уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн;” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг” гэснийг “биометрик мэдээллийг” гэж өөрчилж, 10.1.4 дэх заалтын “эрүү, иргэн, захиргааны болон бусад” гэснийг, 10.2 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон” гэснийг тус тус хасаж, 10.2 дахь хэсгийн “ажилтны” гэсний дараа “зөвшөөрлөөр” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.5.Улсын Их Хурлын гишүүнийг хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор биометрик мэдээллийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	8
Бүгд:	22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.	

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “караоке” гэснийг “караокены өрөө” гэж өөрчилж, мөн зүйлийн “цахилгаан шат” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	8
Бүгд:	22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2, 3 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 13.11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

13.11 дүгээр зүйл.Хувь хүний нууцыг задруулах

1.Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.харилцаа холбоо, цахим сүлжээ ашиглаж;

2.2. Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Эрх бүхий албан тушаалтан” гэснийг “Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, бусдад дамжуулсан, эсхүл эрх бүхий албан тушаалтан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	8
Бүгд:	22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.	

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн.” гэж заасны дагуу ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.2.11 дэх заалтын “мэдээллийн эзний” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	8
Бүгд:	21
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдсэнгүй.	

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон эцсийн хуулбарын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ням-Осорын Учрал танилцуулна.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1, 42.2.3-т заасны дагуу холбогдох зарчмын зөрүүтэй саналуудыг боловсруулан танилцуулж байна аа. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас болон Улсын Их Хурлын гишүүдээс Улсын Их Хурлын гишүүнийг хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулахад гарын хурууны хээгээр

хязгаарлахгүй байх санал гаргасан тул биометрик мэдээллийг ашиглах талаар, хүний хувийн мэдээллийг задруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, ялын бодлогыг ялгамжтай оногдуулах зорилгоор хувь хүний нууцыг задруулсан, түүнчлэн харилцаа холбоо, цахим сүлжээг ашигласан бол 6 сараас 5 жил хүртэлх хорих ял оногдуулдаг байх саналыг тус тус боловсрууллаа.

Түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээллийн хуулбарыг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй өгөхөөр тусгалаа. Төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж төсөлд тусгасан бөгөөд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төслийг бэлтгэж та бүхэнд тараасан болно оо.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагчид баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад түрүүний албан тушаалтнууд, байгаа. Өөрчлөгдсөн хүн байхгүй, тийм ээ.

Танилцуулга болон эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Ганбат гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Хүний хувийн мэдээллийн хамгаалах энэ хуулийн төслийг бол анхнаас нь дэмжиж байгаа. Мөн хэлэлцэх эсэх асуудлыг шийдэх үед бас манай их олон гишүүд нэг асуудал дээр бол их байр суурь илэрхийлсэн. Тэр нь энэ 1996 онд санагдаж байна. 1995 онд ч байна уу баталсан Гүйцэтгэх ажлын тухай хууль гэж байгаа юм. Одоо 25 жил орчим болж байна. Үүнийг хэн ч мэддэггүй. Бүгд нууц. Үүний цаана нь нэг нууц л юм байна гэж. Энэ гүйцэтгэх ажлын тухай хууль бол энэ хүний хувийн мэдээлэл рүү хамгийн хил хязгааргүй нэвтэрч ордог хууль байгаа. Энэ хуулийг хамт шинэчлэхгүйгээр бас энэ Хүний хувийн мэдээллийг хууль бас амилахгүй ээ.

Нэг талаас нийтийн эрх ашиг, улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын эрх ашиг гэж байгаа. Энэ гүйцэтгэх ажлын хууль тогтоомжоор сая өчигдөр Монгол Ардын нам санаачлаад, Монгол Ардын намын удирдах зөвлөлөөс санаачлаад хөндлөнгийн хараат бус бодлогын судлаач нар нэлээн олон сарын турш 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй судлаач нар судалгаа хийлгэж өчигдөр судалгааны үр дүнг бол хуульчдын хүрээнд хэлэлцүүлэг хийж танилцсан байгаа. Энэ судалгааны үр дүнгээр юу гэж гарч байгаа вэ гэхээр хамгийн их одоо эрх нь хөндөгдөж байгаа, Үндсэн хуульд заасан эрхийн нэг нь халдашгүй, чөлөөтэй байх эрх байна аа, иргэний. Тэр дотроо энэ гүйцэтгэх ажлын асуудлыг бол нэлээн тодорхой болгож хуульчлах шаардлагатай гэдэг ийм дүгнэлт гарсан байгаа.

Энэ дотор бол 2 асуудал байдаг юм аа.

1 дүгээрт, энэ үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс дэлхийн аль ч улс хар хайрцгийнхаа бодлогын хүрээнд авч үздэг, тагнуулын байгууллагаас хийгддэг, мэргэжлийн ажил байгаа юм аа. Энэ ажил бол тусгай буюу онцлог. Өөрөөр хэлбэл үүнийг бас нэг хуулийн хана, хэрэмд оруулах гээд нэг бүрчлэн журамлах гээд байдаг ийм харилцаа бол бас биш. Гэтэл энэ одоо ажиллагаагаа гэмт хэрэг шалгадаг нууц мөрдөн шалгах ажиллагаатайгаа нэг хуулиар аваачаад биччихсэн. Гэмт хэрэг илрүүлэх зорилгоор хийгддэг ажиллагаа бол угаасаа нөгөө Үндсэн хууль ёсоороо прокурорын хяналтад байдаг. Прокурорын хяналтад байдаг. Өөрөөр хэлбэл энэ нөгөө шүүх дээр нотлох баримт болдог учраас. Прокурорын хяналт байсан хууль ёсны дагуу хийгдэж байгаа тэр үйл ажиллагаа л шүүх дээр хууль ёсны нотлох баримт болдог. Тэгэхээр энэ нотлох баримт болдог энэ үйл ажиллагаа нөгөө одоо улс орны үндэсний аюулгүй байдлын зорилгоор хийдэг энэ ажиллагаа хоёр бол хоёр өөр ажиллагаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг цаашдаа их нарийн зааглаад хэлэхгүй бол бид нар ганцхан одоо хүний хувийн мэдээллийг одоо хуулийг батлаад энэ асуудлаа цэгцлэхгүй бол бас болохгүй байгаад байгаа юм аа. Энэ дараа нь асуудал үүснэ, дараа нь асуудал үүснэ. Тийм учраас би үүнийг дахин хэлэлцэх эсэх дээр хэлж байсан. Олон гишүүд ч бас хэлж байсан. Энэ гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг боловсронгуй болгох цаашид шаардлага байна аа. Энэ хуультай холбоотойгоор. Тэгэхээр Засгийн газар бас үүнийг одоо бас энэ хуультай холбогдуулж оруулж ирээч ээ гэсэн ийм чиглэл өгөх бололцоо ... /минут дуусав/

С.Бямбацогт: Энэ дээр ажлын хэсэг хариулах уу? Эсвэл бид нар чинь хуулиа дагуулаад чиглэл өгчих л гэсэн асуудал Энхбаяр гишүүн яриад байна, тийм ээ. Энэ тал дээр Баасандорж дарга Засгийн газар ямархуу бодлого чиглэл барьж ажиллаж байгаа юм, энд.

Хууль зүй хотод дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн Баасандорж дарга хариульяа.

Б.Баасандорж: Энхбаяр гишүүний асуултад хариульяа аа. Энэ Хүний хувийн мэдээллийн тухай хуулийн хэлэлцэх эсэх мөн анхны хэлэлцүүлэг дээр саналын томьёолол гарахад яг энэ гүйцэтгэх ажилтай холбоотой буюу хуулийн төслийн 3.4-тэй холбоотойгоор гишүүдээс санал гаргаад санал хураагдсан байгаа. Тэгээд яг тэр тухайн саналын томьёололтой холбоотойгоор мөн тагнуулын байгууллагаас тодруулсан. Засгийн газрын зүгээс энэ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн өөрчлөлтийн асуудлыг тагнуулын байгууллага дээр бол энэ ажил бол явагдаж байгаа. Тэгээд Засгийн газраас одоо холбогдох хуулийн төслийн өөрчлөлтийг бол Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу Засгийн газраас оруулж ирнэ ээ. Хэлэлцэх эсэх дээр, анхны хэлэлцүүлэг дээр энэ асуудал яригдсан байгаа.

С.Бямбацогт: Засгийн газар ямар ч гэсэн бас тодорхой ажлууд хийж л байгаа юм байна. Гэхдээ бас яаж эрчимжүүлэх вэ гэдэг тал дээр манай гишүүд бас анхаарал тавиад манай яамныхан ч гэсэн анхааралдаа бас авчхаарай.

Дараагийн асуулт. Раднаасэд гишүүн асуултадаа асууяа.

Ш.Раднаасэд: Энэ шилжилтийн үеийн зохицуулалт гээд нэг зохицуулалт явж байгаа. Би энэ хугацаа нь жаахан урт тавигдах болов уу гэж анх харж байсан.

Энэ хууль нөгөө хэрэгжих хугацааг. Одоо бид нар чинь 5 сарын дотор тийм, 5 сарын 01-ний дотор хуулиар зөвшөөрснөөс, бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан бие нь давхцалгүй өгөгдөл, гар хурууны хээ гээд л бусад зүйлүүдийг бүгдийг нь устгана гэж тухайн байгууллагууд дээр авагдсан. Засгийн газраас нэг комисс гараад л явчих юм шиг байгаа юм. Ингэж нэг хуулиар одоо ингээд шахаад явах нь зөв үү, үгүй юу, устгахгүй гэхээр ямар хохирол байгаа юм, устгана гэхээр ямар давуу тал байгаа юм бол. Энэ дотор чинь буруу зөрүү жаал юм устгагдчих вий гэж тийм болгоомжлол байна л даа. Тийм. Яг ямар ямар зүйлүүд, жишээлбэл одоо гээд ингээд жагсаалт жишээлбэл энэ хууль хэрэгжихтэй холбоотой гээд судалгаа байгаа даа, түүн дотор чинь одоо ийм ийм мэдээллүүдийг бид устгах юм аа. Энэ энэ байгууллагууд дээр хадгалагдаж байгаа гээд нэг тодорхой тэр жагсаалтууд юм нь байна уу? Эс үгүй бол байхгүй болбол одоо энэ 5 сарын хугацаанд 3 сарын дотор ч гэдэг юм уу, бид нар хайж олоод ингээд устгана гэж тооцож байгаа юм уу? Энэ дээр нэг хариулт өгөөч. Би энэ хуулийн хэрэгжих хугацаатай холбоотой. Энэ зохицуулалт бас уул нь ажлын хэсэг дээр нэг санал өгсөн, тэр нь бас яваагүй юм байна. Энэ дээр нэг тайлбар сонсъё.

С.Бямбацогт: Ажлын хэсэгт Баасандорж дарга хариулах уу.

Б.Баасандорж: Раднаасэд гишүүний асуултад хариульяа. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл дээр шилжилтийн үеийн зохицуулалт байгаа. Энэ дээр бол яг л тодорхой хугацааг бол тавьж өгөөгүй. Зүгээр энэ бол хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл буюу гарын хурууны хээг устгана аа гэж байгаа. Тэгээд энэ үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг Засгийн газрын шийдвэрээр байгуулна аа гээд. Өөрөөр хэлбэл, Хүний хувийн мэдээллийн тухай хуулиар гарын хурууны хээг Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасны дагуу зөвхөн сонгогчийг таньж танихад. Сонгуулийн үеэр. Дараа нь улсын бүртгэлийн одоо үйлчилгээг авахад буюу иргэн 16 нас хүрээд иргэний үнэмлэхээ авахдаа, 25 насандаа шинэчлэхдээ, 45 насандаа сольж авахдаа гарын хурууны хээгийн бүртгэлийн үйлчилгээ авна аа гээд. Бусад тохиолдолд бол үүнийг бол хориглож байгаа.

Өнөөдөр яг энэ хууль одоо хүчин төгөлдөр болохоос өмнө энэ гарын хурууны хээг бол маш олон төрлийн үйлчилгээнд ашигладаг. Жишээ нь, хувийн супермаркетууд одоо мембер болох буюу гишүүнчлэлийнхээ хувьд одоо маш олон тооны гарын хуруу хээг цуглуулсан байдаг. Банк бус санхүүгийн байгууллага, машин худалдаалдаг байгууллагууд гэх мэт энэ их олон төрлийн байгууллагууд дээр зарим нь бол нөгөө хур системийг ашиглаж бас хур системээс шууд үйлчилгээ авдаг. Зарим хувийн хэвшлүүд дээр гарын хурууны хээний бааз үүссэн байдаг. Тэгэхээр тэр гарын хурууны хээний одоо бааз үүссэн, дата үүссэн хувийн хэвшлүүд дээр одоо ажлын хэсэг гараад, үзээд энэ гарын хурууны хээг нь одоо хууль журамд заасны дагуу авах, тэр баазыг авах тийм үйл ажиллагаа явагдах юм. Хувийн хэвшлүүд дээр ихэвчлэн гарын одоо жишээ нь супермаркетууд дээр их байдаг, их байдаг. Гарын хурууны хээ цуглагдсан одоо хэдэн мянган одоо мемберүүдийн гар хурууны хээ цугларсан. Мөн зарим банк бус санхүү дээр байна, зарим одоо дилерүүд дээр байна гээд маш олон төрлийн чиглэлийн үйл ажиллагаануудыг нь гарын хурууны хээг одоо цуглуулсан ийм мэдээллүүд байгаа.

Мөн зарим төрийн болон төрийн бус байгууллага дээр нэг цагийн бүртгэлүүд байдаг. Цагийн бүртгэлээр энэ гарын хурууны хээг авсан мэдээллүүд байдаг. Тэгэхээр энэ мэдээллүүд дээр л одоо шалгалт ороод Засгийн газраас

холбогдох хууль хяналтын байгууллагаас оруулсан ажлын хэсэг ажиллах юм.

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Надад 2 зүйл байна. Ер нь бид нарын хүний хувийн мэдээлэл хамгаалах, нөгөөх маань явсаар байгаад мэдээллийн ил тод байдал, мэдээллийн ил тод байдлын тухай хууль болох юм шиг байна. Энэ чухал хууль. Тэгээд Кибериин хууль, гарын үсгийн хууль гээд энэ 4 чухал хууль гарч байгаа. Энэ бас тодорхой хэмжээгээр дэвшил болно oo гэж ингэж бодож байгаа. Би ажлын хэсэгт нь орж ажилласан.

Энэ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль дээр би тэр сая Энхбаяр гишүүний хэлж байгаатай санал нэг байгаад байгаа юм. Энэ Учрал гишүүн мэдэж байгаа, би энэ дээр бол идэвхтэй оролцсон шүү дээ. Зүйл бүрээр та ингэж ярьсан. Бид нар цаг зарсан. Энэ дээр би ингээд байгаа байхгүй юу. Энэ бусад хуулиар зохицуулснаар гэдэг нэг том уутыг энэ хэдэн жилд дандаа явдаг байсан. Үүнийг хасах ёстой гэсэн. Гэтэл энэ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль дээр Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан зохицуулсан юм. Гүйцэтгэх ажлын тухай хууль нь хүний эрхийг зөрчиж болохгүй байхгүй юу. Тэгэхээр та нар энэ дээр бодож үзээч. Би ер нь юунд дургүй вэ гэхээр хувь хүний хувийн мэдээлэл хамгаалах үндсэн хууль бол энэ хууль. Бусад янз бүрийн хуулиар хүний хувийн мэдээллийг хулгайлж болохгүй. Тагнаж болохгүй, ашиглаж болохгүй. Тэгэхээр түүнийг хийх гэж байгаа болбол би үүнийг л хасах ёстой гэж үзэж байгаа юм. Тэр гүйцэтгэх ажлын хууль чинь ч хүний эрхэнд халдаж болохгүй. Одоо манайхан ингээд тагнаж болно, чагнаж болно. Тэр чинь өөрөө нарийн процедуртай тэр процедурынхаа дагуу хийгдэг ажиллагаа байна уу гэхээс биш Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан зохицуулснаас бусад хувь хүний нууцтай холбоотой харилцаа. Бид нар үндсэн энэ хүний нууцын үндсэн хуулийг л зөрчиж байна даа. Надад нэг ийм одоо санаа байна.

2 дахь нь бол энэ би одоо үүнийг нэг юм хэлчихье. Энэ одоо үүнтэй хамаагүй мөртөө нууцдаа хамаагүй юм л даа. Тэгэхдээ энэ улсын төсөв ер нь болохгүй байна. Та нар үүнийг хар даа. Би Улсын Их Хурал өөрөө нэг стандарттай болооч ээ гэж хэлэх гэж байна. Би сая нэг залуу үүнийг авчирч өгөхөөр нь цочлоо. Үгүй ээ чи юун их зузаан юм надад авчирч өгч байгаа юм гэсэн. Энэ хар аа. Энэ зүгээр хууль хүчингүй болсон тухай юмыг ингээд принтэлж өгч байна. Тэгээд одоо би чинь нөгөө манай гэр чинь хүмүүжилтэй их арвилан хэмнэдэг айл байсан. Дээр нь Сангийн сайд байсан. Энэ хар л даа. Энэ хар аа, ийм цав цагаан цаасны толгой дээр нь ингэж бичнэ. Дахиад хар даа. Ийм цав цагаан сайхан цаас нөгөө тал нь цав цагаан. Энэ одоо юу юм. Үүнийг бас хэлэхгүй бол одоо энэ цаасаа ав л даа, энэ би тэгээд хүнээс асуулаа. Ийм цаас ямар үнэтэй байдаг юм гэсэн, 500 ширхэгтэй энэ цаас 11000 төгрөг байна. Энэ одоо миний нүдэн дээр надад 2000 гаруй төгрөг устгуулж байна. Үгүй ээ, энэ ард түмний хөрөнгийг ингэж үрж болохгүй ээ. Улсын Их Хурал өөрөө стандарт гаргаач. Тэгээд би энэ бичиг цаасыг үзэхээр заримыг нь одоо ингээд ийм том шриптээр бичих юм. Заримыг нь ийм жижиг шриптээр бичих юм. Үгүй ээ энэ манай улс чинь. Ер нь энэ стандарт гэж хүн байна уу? Мөнгө цаас, хэмнэдэг бодлого гэж ер юм байна уу? Үүнийгээ ав, би одоо үүнийг хэрэглэхгүй. Яаж байгаа юм бэ? Энэ тэртээ тэргүй хар аа, сүүлчийн хэлэлцүүлэг дээр энэ чинь бараг ач холбогдолгүй шүү дээ, тийм ээ. Тэгээд хэвлэдэг юм болбол ингээд л хэвлээд л өгчхөөч дээ. Миний одоо үндсэн нөгөө хүний нууцыг хамгаалах хуулиар ярих гэж байсан бүх санааг минь энэ устгалaa.

Одоо өдөр болгон Их Хурлын 1 гишүүнд 1 хуулийн төсөл хэлэлцэхэд 2000 төгрөг устаад байвал энэ яах юм ... /минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Учрал гишүүн хариульяа, асуултад.

Н.Учрал: Энэ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийн үеэр Байнгын хорооны хуралдаан дээр Мөнх-Оргил гишүүн, Нямбаатар гишүүн, Сүхбаатар нарын гишүүд төслийн 3.45 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах санал гаргасан. Тэгээд дэмжигдсэн. Тэгэхээр анхны төсөл дээрээ болбол 3. 4 буюу Алтанхуяг гишүүний гаргаж байгаа асуулттай холбогдуулаад гүйцэтгэх ажлын явцад мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахдаа хамгаалахтай холбогдсон харилцааг гүйцэтгэх ажлын хуулиар зохицуулнаа гэж ерөнхий байдлаар ингэж зохицуулсан байсныг З гишүүний саналаар гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан зохицуулснаас бусад хувь хүний нууцтай холбоотой харилцаа гэж ингэж томьёолж болбол илүү тодорхойлж өгсөн. Ингэснээрээ бол Гүйцэтгэх ажлын хуулиар тусгайлан зохицуулаагүйгээс бусад харилцаа болбол энэ хуульд хамарагданаа гэсэн ойлголт бол явж байгаа.

Эхний тэр Засгийн газраас орж ирсэн санал дээр болбол мэдээллээ цуглуулаад боловсруулаад ашиглаж байх тэр холбогдсон бүхий л харилцааг гүйцэтгэх ажлын хуулиар зохицуулнаа гээд ингээд энэ хуулиар зохицуулахгүй юм шиг ойлголт байсныг нь нарийвчилж зохицуулах энэ санал бол дэмжигдээд эцсийн хэлэлцүүлэг дээр өөрчлөн найруулаад та бүхэнд танилцуулж байгаа.

Энэ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль дээр манай ажлын хэсэг бол сайн ажилласан. Тэгээд Алтанхуяг гишүүн бас нэлээн олон саналуудыг гаргаад бид нар бас хуульд өөрөөр заагаагүй бол гэсэн олон зохицуулалтууд байсныг бол энэ хуулиас хассан. Нэг мөр ойлгох үүднээсээ. Хүний нөгөө мэдээллийг бол дотор нь эмзэг мэдээлэл, хувийн мэдээлэл гэж ангилаад хүний эмзэг мэдээлэлд хамарагдаж байгаа үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцааны нууц, генетик, биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, нөгөө ял эдэлж байгаа бол ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг хүний эмзэг мэдээлэлд хамааруулж байгаа буюу яг эдгээр мэдээлэл болбол хүний хувийн нууцад хамаарнаа гэсэн үг.

Тэгэхээр энэ өөрөө Хүний хувийн нууцын хуулийн шинэчилсэн найруулга болбол бас энэ хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль. Тэгэхээр ерөнхийд нь хувь хүний нууцад хамааруулнаа гэж авч үзэж байсныг, дотор нь одоо нөгөө sensitive мэдээлэл гээд хүний эмзэг мэдээлэл дотор эдгээр мэдээлэл нь хамаарах юм байна. Эдгээр мэдээллийг хүний хувийн нууцад хамааруулах юм байна. Хуулийн гол концепц нь эдгээр мэдээллийг цуглуулж, боловсруулж ашиглахдаа мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоноо оо л гэдэг заалтыг тодорхой болгож өгөх үүднээсээ болбол энэ мэдээллийг эмзэг, хувийн гэж бол ангиликж өгсөн. Тэгэхээр тэр Гүйцэтгэх ажлын хуулиар тусгайлсан зохицуулснаас бусад бүх харилцааг энэ хуулиар зохицуулнаа гэсэн бол санааг бас оруулж өгч байгаа.

Сая тэр нөгөө цаасны хэрэглээний тал дээр бас нэг зүйлийг хэлэхэд Их Хурлын гишүүд бол цаасан хэрэглээнээс татгалзах бололцоо бүрэн байгаа. Одоо энэ бидний хэрэглэж байгаа аппликашн байгаа шүү дээ. Одоо ай пад дээр байгаа

энэ апликацыйн дээр бүх хуулиуд тавигдаад явж байгаа. Байнгын хорооны энэ шигтгэсэн хувилбаруудыг тэр апликацыйн дээрээ тавиад тэр май парл дээрээ тавиад л явах юм бол нэг ч цаас тараахгүй явж болно оо гэж байгаа юм. Тэгээд өмнө нь ч гэсэн Их Хурлын дарга ч гэсэн ингээд цаасгүй явъя аа гэж санаачилж байсан. Гэхдээ цаасгүй явъя гэхээр ай падаа орхичихлоо, цаасаар авмаар байна гээд гишүүд ингээд л эхэлдэг байхгүй юу. Тэгэхээр яг үнэхээр нэг мэр хэрэглэж чадна аа гэвэл бүгдээрээ цаасан хэрэглээнээс татгалзчих юм бол манай энэ Байнгын хорооны ажлын албаныханд бүр их амар болно. Энэ их олон хэвлэх материал тараагаад байх энэ хүмүүс бол ерөөсөө дуртай байхгүй байгаа шүү дээ. Бид нар өөрсдөө л цаас нэхээд байгаа. Тэгэхээр цааснаас салъя гэвэл хамтдаа яг шууд салчихвал одоо ч салахад бэлэн байна аа.

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Алтанхуяг: Өчигдөр ажлын хэсгийн нөгөө бас хуралдаан болсон л доо. Учрал дарга. Би үүнийг сайн ойлгоогүй. Та нарын яриа надад нөгөө цахимаар орсон чинь их муу сонсогдоод байсан юм. Тэгээд би бол ийм саналтай байгаа шүү дээ, энэ дээр. Тэр бусад мэдээллийн тухай би яриагүй. Энэ цахим бичлэгийг худалдсан эсвэл тэр эрхтэн дархтууд очиж цахим бичлэгийг янз бүрийн байдлаар аваад олон нийтийн сүлжээгээр тараасан болбол тэр хүнд торгуулийн ял ерөөсөө үйлчлэхгүй ээ. Наад чинь зориуд одоо манай нийгэм ийм зохион байгуулалтын ажиллагаа хэдэн жил болчихсон. Тэр хүнийг эрүүгийн хариуцлага л хүлээлгэх гээд байгаа юм. Тэгэхээр өчигдөр би ингээд нэг муухан сонсохоор ингээд байх юм. Та нар. Торгоно, зорчих эрхийг хязгаарлана гээд таслал тавиад тэгээд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Миний санаа бол тийм биш. Ерөөсөө энэ видео бичлэгтэй холбоотой асуудлаар бол торгоно ... /минут дуусав/

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн гүйцээгээд асуучихъя, минутыг нэмье.

Н.Алтанхуяг: Энэ, одоо энэ манай Баасандорж дарга та нар ингээд сууж байна, би болбол одоо танай салбар биш гэж байнга хэлдэг. Тэгэхдээ миний концепц ийм. Шүүгч нарт юм уу, иргэдэд та нар нэг мэр ойлголт өг өө. Ийм мэдээллийг та нар ингээд задруулах юм уу, худалдах юм уу, ашиглах юм уу, цацах юм уу ингэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээнэ ээ. Шууд хорих ялаар шийтгэнэ ээ гэдгийг хэлж өг. Тэгэхгүй бол та нар ийм эрх чөлөө өгөөд байгаа байхгүй юу. Шүүгчид очоод тортож ч болох юм шиг, нэг хэд хоног гэрт нь хорьчхож болох юм шиг. Одоо широнд хорьж ч. Ийм өргөн спектртой юм өгч болохгүй ээ гэж би хэлж байна. Тэгэхдээ бүх юман дээр биш, зөвхөн видео дээр, одоо олон нийтэд тэр манай нийгмийг үл итгэлцүүлж, хооронд нь дайсагналцуулж бие биеэ хоёулаа зэрэгцэж сууж байгаад муухай хараад байгаа юмны чинь аймаар урхагтай юм энд байгаа юм л даа. Та нар үүнийг нэг мэр шийдэж өгөөч ээ гэж би хүсэж байна.

С.Бямбацогт: Сайнзориг дарга хариулья тодорхой. Бас яагаад энэ протоколд бас тэмдэглэгдэж үлдэх ёстой байх тийм ээ, тэгээд л үзэмжээрээ

П.Сайнзориг: Алтанхуяг гишүүний асуултад хариулья аа. Тэгээд өчигдөр яг ажлын дэд хэсэг дээр ажлын хэсэг хуралдахаас өмнө ажлын хэсэгт оруулсан саналыг бид нар ярилцаад эргээд энэ хувь хүний нууцыг задруулах асуудал бол үндсэндээ ялын бодлого бол бага зэрэг сүл байгаа. Үүн дээр бас таны саналыг үндэслээд энэ гэмт хэргийг одоо яг харилцаа холбоо болон цахим сүлжээ ашиглаж

буюу энэ сошиал медиа ч гэдэг юм уу энэ цахим технологийг ашиглаад тараах юм бол 1-5 жилийн хорих ялтай байдлаар оруулж ирж байгаа. Тэгэхдээ яах вэ, зүгээр таны бас шүүмжилж байгаа нэг асуудал юу вэ гэхээр зөвхөн хорих ялыг тавь аа. Торгох ялыг нь авч хая аа гэсэн одоо саналыг хэлээд байгаа. Ер нь бол одоо Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан одоо гэмт хэргүүд дээр бол нийгмийн аюулын хор аюул нь өндөр. Ийм тодорхой гэмт хэргүүд дээр зөвхөн хорих ялтай байгаа. Бусад аливаа гэмт хэргүүд дээр сонгох санкцтai байж байгаа. Тэгэхээр бид нар бас энэ бодлогоо бариад ерөнхийдөө торгох болоод зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ялтай байдлаар оруулж ирж байгаа юм. Тэгэхэд тухайн үйлдэл болгон дээр нь бас шүүх бас тодорхой хэмжээний тохируулж хэрэглэх бололцоог нь олгохгүй бол магадгүй санаандгүй байдлаар задруулчихсан хүн дээр шууд хорих ял бас өгч болохгүй болчкоод байгаа юм. Эргээд энэ задруулсан үйл ажиллагаанаас тэр, тухайн тэр гэмт хэргийн хохирогч болж байгаа этгээд учруулж байгаа хохирлын хэмжээ ч гэдэг юм уу маш олон зүйлүүдийг нь бас харгалзаж үзэж байж бас энэ ялыг бас сонголтыг хийнэ ээ. Шүүхээс. Тэгэхээр энэ бололцоог нь бас өгөхгүй бол хэт бас хатуу байх юм бол өнөөдөр энэ хүний хувийн мэдээллийг хамгаалах энэ соёлд бид нар бас хараахан гүйцэд дадаагүй байгаа энэ үе дээр хэт бас хатуу ялаар явах нь сүүлдээ нөгөө талдаа бас сөрөг үр дагавар гарагыг бас зарим талаараа үгүйсгэх аргагүй байгаа юм аа. Тэгэхээр энэ удаад ямар ч байсан гишүүдийн хэлж байгаа энэ чиглэлийн дагуу бид над ял хариуцлагыг бас тодорхой хэмжээнд хорих ялыг нэмэгдүүлж орж ирж байна.

Цахим сүлжээгээр тараасан гэдэг үйлдлийг тодотгож, нэмж оруулж өгч байгаа. Ийм байдалтайгаар энэ Эрүүгийн хууль дээр хураах гэж байгаа саналын гуравдугаар санал дээр таны санал хураагдана аа гэж хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Тэгэхээр яах вэ. Энд хүндрүүлж л байгаа юм байна л даа. 2.2 дээр нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх гэж байгаа юм. Энэ чинь одоо таван мянга гэдэг чинь таван сая төгрөг гэсэн мөн үү? Тэгээд таван саяас хорин долоон сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эс үгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ ээ гээд. Ийм өргөн байгаад байна л гэж яриад байна л даа.

Тэгээд ямар тохиолдол нь тэр таван саяар торгох юм? Ямар тохиолдол нь таван жилийн хорих ял яах юм үүнийгээ бас нэг протоколд яг ингэж ойлголцож ингэж хийсэн шүү гэхгүй болбол нөгөө хууль хэрэглэхдээ дээрээс нь ял завших бас ийм асуудлууд бас гарч их эрсдэл байгаад байна. Алтанхуяг гишүүн асуугаад байна шүү дээ. Тэгэхээр нэг протоколдоо үүнийг бас. Тэгээд хариулт байхгүй юу.

Дээрээс нь харилцаа холбоо, цахим сүлжээ ашиглаж бас байгаа тийм ээ. Нэмэлт хариулт байхгүй юу. Сайнзориг хариульяа дарга.

П.Сайнзориг: Яг сая Бямбацогт дарга бараг уншаад өгчихлөө л дөө. Ер нь бол өмнө нь тэр харилцаа холбоо, цахим сүлжээ ашиглаж гэдэг асуудал байгаагүй. Энэ өөрөө эргээд маш богино цаг хугацаанд өргөн хүрээг хамарсан хүнд тэр худал мэдээллийг гэдэг юм уу, хувь хүний нууцыг хүргүүлэх задруулах бололцоог бүрдүүлж байгаа учраас үүнийг бид нар Алтанхуяг гишүүн болоод ажлын бусад хэсгийн гишүүдийн чиглэлийн дагуу бол гэмт хэргийн шинж дээр нэмж тодорхойлж өгч байгаа. Хүндрүүлэх бүрэлдэхүүн дээр нь.

Хоёрдугаарт яах вэ. Би сая хэлсэн. Үйлдлийн тэр гэмт хэргийн бас шинж, нийгмийн хор аюул, эргээд тэр гэм буруугүйн байдал, хохирогчид үзүүлсэн тэр бусад хохирлын хэмжээ зэргийг харгалзаж үзэж, бас энэ ялыг сонгох сонголтыг бас шүүх оногдуулахгүй бол хэт бас одоо зөвхөн хорих ял оногдуулна аа гэх юм бол бас зарим талаараа сөрөг үр дагавар гарна аа. Өнөөдөр бас манай нийгэм хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудал дээр бас хараахан бас гүйцэд дадал соёлд бас хэвшээгүй байгаа. Тэгэхээр бид хэд үүнийг бас үе шаттайгаар үзэж байж цаашдаа бас илүү их хуулийн хэрэгжилтийг, бас одоо тодорхой цаг хугацаанд харсны дараа ял хариуцлагыг илүү их, бас тодорхой болгон одоо юу гэдэг юм болгоомжтойгоор үе шаттайгаар нэмэгдүүлэх бас бололцоог бас л судалж үзнэ ээ гэдэг зүйлийг бас дахин тодотгож протоколд үлдье ээ.

С.Бямбацогт: Тэгэхээр хор уршгаас нь хамааруулж хамаарч үндсэндээ бол ялын санкц сонгогдох нь байна шүү дээ.

Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Их олон ч юм асуугаад яах вэ. Ганц нэг юмыг нэг тодруулчихъя гэж бодож байна.

Тэр авсан мэдээллээ хариуцахгүй алдагдуулчихсан байвал яах юм бэ, энэ одоо тэрийн байгууллагууд. Сайхан, сайхан дарга нар, сайхан сайхан агентлагууд байх шиг л байх юм. Одоо тэр Хятадын сайт дээр чинь 2 сая Монгол хүний мэдээлэл долоон зуун мянган доллароор, долоон зуун доллар байх аа, далан доллар ч билүү зарна гээд л байж байна гэсэн шүү дээ. Тэр ямар учиртай юм бэ? Нэг.

Хуульгүй байснаас хуультай байсан нь дээр юм байна лээ гэж ойлгож байгаа. Ямар ч байсан нэг хуультай больё. Нөгөө талаар одоо наад гаргах гээд байгаа хууль чинь одоо бараг үүрэндээ өтөлж байгаа юм биш үү. Тэр дэлгүүр супермаркет энэ тэрийг зохицуулдаг л юм байгаа биз. Тэрийг нь авдаг л юм байгаа биз. Одоо энэ Монголд айл болгонд нэг койнчтой болсон. Үнэхээр мэдлэгтэй, боловсролтой, чадалтай хүн гэвэл тэр койн зөв. Тэрийг нь тайлбарлаж байгаа хүн амьтан ч алга. Тэгээд бүгд л оролцоод явж байгаа. Их олон биржүүд байна. Бараг 6, 7 бирж байна гэж би ойлгож байгаа. Тэр биржүүд бүх хувь хүний мэдээллийг авч байгаа шүү дээ. Тэрийг одоо яах юм? Тэрийгээ ингээд зохицуулж байгаа юм уу, зохицуулахгүй байгаа юм уу?

Тэгээд сая цаас хэмнэх талаар ярилаа л даа. Сайн л байна л даа. Үгүй ээ, энэ чинь цааснаасаа гадна тэр тэрийн нууцад оруулаад баллаж байна шүү дээ. Энэ Ардын нам олонх болонгутуулж л 2016 онд л тэр хуулиа өөрчилсөн юм байна. Яагаад ч одоо бүх юмыг тэрийн нууцад авдаг болчихсон юм. Тэр Засгийн газар нь. Уул нь Улсын Их Хурал дээр л шийддэг байсан шүү дээ. Одоо хар л даа. Тэр Богд зонховын хөшөөг 32 тэрбумаар л барьж байна гэж байна. Үүний хажууд одоо нэг муу цаас юу юм. Одоо удахгүй хэдэн их наядаар гарч ирэх байх аа. Тэр нууцад авсан янз бүрийн төмөр зам, Богд зонховын хөшөө бол ерөөсөө л мөсөн уулын оргил нь шүү дээ. Зүгээр үгийн далимд нэг товчхон хэлчихэд нэг иймэрхүү л байна даа.

С.Бямбацогт: Учрал гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Н.Учрал: Ганбат гишүүний асуултад хариулъя. Энэ Нийтийн мэдээллийн хуулийг бол сая бид нар эцсийн хэлэлцүүлгийг нь хийлээ. Тэгээд Нийтийн мэдээллийн хуулиараа мэдээллүүд нээлттэй болсноор одоо яг таны яриад байгаа тэр Богд уулын хашаа хатгачихсан байгаа эзэмшигч нар ил болно оо. Нөгөө ашигт малтмалын лиценз эзэмшиж байгаа компани, аж ахуйн нэгж нөхдүүд бүгд ил болно оо. Mash олон зүйл ил тод болно. Тэгэхдээ үүнийг сэтгүүл зүйн зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр сэтгүүлчид авч ашиглахыг зөвшөөрнө. Бусад тохиолдолд хувь хүний нууцад хамааруулах мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр цуглуулах, боловсруулж ашиглахыг хуулиар нь хориглож байгаа. Энэ Хувь хүний мэдээллийн хуулиар. Тэгэхээр янз бүрийн мэдээллийг аваад олон нийтэд тараадаг энэ байдлыг бол одоо энэ Эрүүгийн хуулиар зохицуулж өгч байгаа юм. Жишээ нь, та сая дурдсан. Зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах хоёр одоо нөхцөл байдалд байгаа. Нэг нь оршин суугчийн зөвшөөрөлгүй жишээ нь орон байранд эс үгүй бол гадна талаас нь орон байрны доторх орчны болон орох, гарах хэсгийг хамруулан гэрэл зураг аваад дуу дурсний бичлэг хийж байгаад түүнийгээ олон нийтэд тараасан дээр бол. Бас хорих, энэ тохиолдолд болбол торгох, зорчих эрхийг хязгаарлах ялтай.

Харин хувь хүний халдашгүй чөлөөтэй байх гэхэд илтэд халдахаар байршилд дууны, дурсний бичлэгийг хийж олон нийтэд тарааж бусдад дамжуулсан бол зорчих эрхийг хязгаарлах торгохоос гадна хорих ялтай байхаар энэ хуульд тусгаж өгч байгаа юм. Дээрээс нь түрүүн хэлсэн албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээллийг хувь хүний нууцад тэр хувь хүний нууцыг задруулсан бол мөн торгох, зорчих эрхийг хязгаарлах, эсвэл одоо хорих ял шийдэгдэж байгаа юм. Тэгэхээр анхны хэлэлцүүлгийн үеэр энэ ялын бодлогоо чангатта аа гээд бас гишүүд санал хэлсний дагуу ялын интервалуудыг болбол жигдэлсэн. Торгуулийг нь бол өндөрсгөсөн, зорчих эрхийг 2 жил хүртэлх хугацаагаар нэмэгдүүлж, дээрээс нь нийт тустай ажлаа хасаад хорих ялыг бас нэмэгдүүлсэн. Нэг ёсондоо бол ялын бодлогыг чангатгасан ийм зохицуулалтыг хийсэн.

Саяын тэр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хуулийг бид нар бас хэлэлцэж байгаа. Тэгэхээр энэ хуулиар бол тэр үйлчилгээ үзүүлэгч нар өөрсдөө мэдээлэл хариуцагч этгээдүүд, мөн нэг ёсондоо болбол үйлчилгээ үзүүлэгч нараасаа мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа гэсэн үг. Тэгэхээр иргэддээ ч гэсэн бас анхааруулж хэлэхэд одоо янз бүрийн фэйсбүүк дээр, эсвэл вэб хуудсууд дээр ингээд орох гэхээр та нараас зөвшөөрч байна уу, үгүй юу? Зөвшөөрөл хүсдэг, тэгээд нэрээ регистртэйгээ хий, дандаа зөвшөөрөл хүсдэг. Энэ болбол хуулийн хүрээнд нөгөө өөрөө мэдээллийн эзэн зөвшөөрч байгаа гэсэн үг. Тэгэхээр үнэхээр ингэж зөвшөөрлийг өгөхдөө иргэд маш болгоомжтой бас хандах ёстой. Мэдээллийг өөрөө зөвшөөрч байгаагаа илэрхийлэхдээ. Тэгэхээр тэр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нараараа ч гэсэн үйлчилгээ үзүүлэгч нар өөрсдөө тэр нөгөө виртуал хөрөнгө авч байгаа талынхаа мэдээллүүдийг бас авч байгаа, цуглуулж боловсруулж байгаа гэдэг утгаараа хариуцаж байгаа учраас аюулгүй байдлыг нь ч гэсэн одоо харин энэ хувь хүний нууцын хувиар, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулиар цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа бол давхар хариуцлагаа хүлээлгэхээр болж байгаа. Өмнө нь болбол иргэн өөрөө л хариуцлага хүлээ гэдэг байсан бол одоо тэр цуглуулж байгаа тал чинь, боловсруулж ашиглаж байгаа тал чинь өөрөө заавал хариуцлагаа хүлээнэ. Тэгэхээр тэр нь болбол албан үүргээ гүйцэтгэх л явцдаа олж авсан мэдээлэл

байна уу, бусад одоо тохиолдолд ажил олгогч ажилтнаас авсан мэдээлэл байна уу, мэдээллийг цуглуулж л байгаа бол тухайн цуглуулж байгаа хариуцагч тал эндээс хариуцна. Алдагдаад бусдад задруулах, дамжуулах, олон нийтэд түгээх дээр болбол бүгдээрээ Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээж байгаа гэсэн үг.

С.Бямбацогт: Ганбат гишүүн тодруулья. Дараа нь хариулья.

Д.Ганбат: Би бол одоо тов тодорхой л асуулт асуусан л даа. Бүр кэйс заагаад. Тэр Хятадуудын сайт дээр яахаараа 2 сая Монголчуудын мэдээлэл байж байдаг юм бэ? Яахаараа дал юм уу, долоон зуун доллароор үнэлнэ гээд байж байдаг юм. Тэрийг одоо мэдэж байгаа, барьж байгаа хүн амьтан байна уу гэж байгаа шүү дээ. Бид нар чинь одоо технологийн газар гээд л нэг газар байх юм. Ямар юмны Байнгын хороо гээд л нэг Байнгын хороо байх юм. Тагнуулын газар гээд л байж байх юм. Үгүй ээ, хүн болгонд л илт байна шүү дээ тэр юм чинь. Тэр нь тэгээд хариулахгүй юм.

Хоёрдугаарт, тэр койны биржүүд, би гадаадын платформуудыг яриагүй, фэйсбүүк, инстаграм, твиттер энэ тэр гээд яриагүй шүү дээ. Би одоо энэ дотоодод үүсээд байгаа койны биржүүдийг яриад байна шүү дээ. Түүн дээр одоо ямар мэдээллийг яах юм. Ямар арга хэмжээ авч байгаа. Үүгээр яг зохицуулсан юм байна уу. Энэ хуульд гэж асуугаад байна л даа. Тэгээд хариулахгүй юм.

Нөгөө талаар алив бас жоохон нэмээд өгчхөөрэй.

С.Бямбацогт: Ганбат гишүүний микрофоныг нэмье ээ.

Д.Ганбат: Хууль зүйн байнгын хороон дээр байхгүй байгаа юм байна. Бас юу байна аа. Энэ мэдээллийг бас тарааж байна аа. Одоо ний нуугүй хэлэхэд татвар төлөгчдийн мөнгөөр цалинжиж байгаа энэ Засгийн газар, энэ агентлагууд бүгд өөрсдөө одоо тийм судалгаа шинжилгээний газартай болчихсон. Тэгээд тэр дарга нарынхаа юун дээр ямар юм явж байна гэдгийг нь цуглуулдаг, боловсруулдаг тийм юм байна гэж байна. Нөгөө талаар бүгд бас нэг сайдтай юм уу, сэтгүүлчтэй болчихсон. Худалдагдсан сэтгэл зүй гэж. Түүгээрээ одоо зориуд захиалгатай хувь хүний мэдээллийг явуулдаг, асуудаг. Тэрэндээ унагадаг ийм юм байна. Үүнийг одоо яах юм.

С.Бямбацогт: Баасандорж дарга хариулья. Дараа нь Тагнуулын ерөнхий газар.

Ганбат гишүүний асуултад хариулья аа, Баасандорж.

Ганбат гишүүн нөгөө хувь хүний нууцыг задруулахтай холбоотой яг асууж байна. Ер нь бол маш товчхондоо бол хувь хүний нууцыг задруулбал Эрүүгийн хууль ажиллаж эхэлнэ. Хувь хүний нууцаас бусад төрлийн мэдээллийг задруулбал Зөрчлийн хуулиар шийтгэл ногдуулна. Тэгээд яг үүнтэй холбоотой яг сая Учрал дарга бас хариулсан. Нөгөө хоёрын хоёр дээр саналын томьёоллоор орж ирж байгаа. Ганбат дарга бас юуг бас асуулаа. Алтанхуяг гишүүн бас мөн хөндсөн. Ер нь энэ цаасан суурьтай баримт бичгийг ингэж одоо төсвийн хэмнэлттэй холбоотой, энэ цаасан суурьтай баримтуудыг яах юм бэ гэдэг асуудлыг Нийтийн мэдээллийн тухай хуулиар зохицуулсан байгаа. Нийтийн мэдээллийн тухай хуулийн 30.1 дээр хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл хариуцагч баримт бичгийг үйлдэхдээ, дамжуулахдаа, хүлээн авахдаа, хадгалахдаа, хамгаалахдаа болон ашиглахдаа

цахим баримт бичигт суурилна аа гээд. Тэгэхээр өөрөөр хэлбэл яг тэр хуульд нь тусгайлан заагаагүй цаасан суурьтай гэж. Одоо жишээ нь бүртгэл дээр жишээ авах юм бол газар, гэрлэлт бол заавал цаасан суурьтай байна. Энэ бүртгэлийн үйлчилгээ. Бусад одоо үйлчилгээ нь цахим суурьтай явна аа гэвэл энэ төрийн үйлчилгээ, бүх үйлчилгээ бол цахимаараа явна аа ... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Баасандорж даргын микрофоныг нэмж өгье.

Б.Баасандорж: Өөрөөр хэлбэл яг энэ манай Нийтийн мэдээллийн тухай хууль хэрвээ батлагдаад хэрэгжиж эхлэх юм бол бид нар хуулийн төслийг боловсруулах судалгаа хийсэн. 1 жилд 10 тэрбум орчим төгрөг энэ цаасан суурьтай төрийн үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагддаг юм байна лээ. Тэгэхээр энэ яг ингээд цахим суурьтай яваад ирэх юм бол ер нь бол 80-90 орчим хувь нь цахим төрийн үйлчилгээ явуулна гэж одоо судалгаа гарсан байгаа. Тэгэхээр энэ тооны одоо хэмнэлт гарна аа л гэсэн үг юм. Тэр тагнуулын байгууллагатай холбоотой юмыг тагнуулын дарга.

С.Бямбацогт: Ер нь бол зүгээр манай гишүүд л өөрсдөө цаасаа нэхээд байгаа шүү дээ. Бусдаар бол Их Хурлын Тамгын газраас ай пад өгчихсөн. Ай пад дээр бүх май парлд бүх материал орчихсон байж байгаа. Тэгээд л орж ирчхээд л материал өгөхгүй, материал тараасангүй, одоо өг гээд л өөрсдөө нэхдэг. Тэгээд цаасаар өгөхөөр одоо цаасаар өглөө. Цаас хэмнэж болохгүй ээ гэдэг бас ийм байж болохгүй л дээ.

Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Эрдэнэ ээ тэр Монголчуудын мэдээлэл гадаадын сайтаар зарагдана гэсэн асуудлаар хариулт өгчихье.

Гишүүдийн амрыг эрье. Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Эрдэнээ хариулт өгч байна аа. Ганбат гишүүний асуусан асуулттай холбогдуулаад тэр 2,3 сая иргэний мэдээлэл гэдэг асуудал нь болбол энэ рейт форум гэж одоо нөгөө хакеруудын олсон алдагдсан мэдээллүүдийг борлуулдаг, зардаг ийм одоо хар зах маягтай ийм сайт байдаг. Энэ сайт дээр зарагдаж байсан мэдээлэл байгаа. Энэ мэдээлэл нь болбол 10 сарын 06-нд болбол анх тухайн сайт дээрээ тавигдсан. Тэгээд манайд болбол энэ асуудалтай холбогдуулаад тодорхой одоо шалгах чиглэлийн ажлын хэсгүүд гараад энэ дээр бол ажиллаж байгаа. Тэгээд ерөнхийдөө бол тэр тавигдсан мэдээллээс үзэхэд бол эхний ээлжид харахад энэ Хаан банкны мэдээлэл юм байна гэдэг тэр юу нь бол тэр дансны дугаар болон зүгээр энэ тавигдсан нэг энэ ил тавигдсан тэр мэдээллээс нь харахад болбол тэгж дүгнэж болохоор байгаа. Үүнээс, цаашаагаа нарийн мэдээллүүдийг нь болбол бас шалгаж байгаа учраас үүнтэй холбогдолтой асуудлыг яг энэ нийтэд болбол ингэж бас ярих, танилцуулах боломжгүй байгаа. Энэ асуудлаар бас манайх нөгөө чиглэл авч шаардлагатай бол тухайлсан бас танилцуулга мэдээллүүдийг Их Хуралд танилцуулж болохоор байгаа. Ингэж илтгэлийг дуусгая аа.

С.Бямбацогт: Болчихсон. Энх-Амгалан гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Доржханд гишүүн 1, 1 минутаар товчхон асуучихъя. Тэгэх үү. Саналаа хэлэх юм уу. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Энэ хувь хүний нууцын тухай асуудал, нийтийн мэдээллийн тухай асуудал, виртуал хөрөнгийн тухай асуудал, цахим гарын үсгийн асуудал

гээд. Ингээд нэлээн олон хуулиуд зэрэг зэрэг орж ирж байна л даа. Би энэ дээр нэг л зүйл дээр жоохон эмзэглээд байгаа юм. Бид нар болбол яг зүйрлэж хэлэх юм болбол хаалга нь онгорхой, хаяа нь онгорхой, тооно нь онгорхой, авдар сав нь цоожгүй нэг ийм гэр дотор л шороо оруулахгүй байх тухай, вирус оруулахгүй байх тухай, халдлага оруулахгүй байх тухай юм яриад байгаа юм л даа. Яг нарийндаа яривал бид нар чинь интернетийн эх үүсвэр нь гаднын хамааралтай шүү дээ. Хоёр эх үүсвэр чинь хоёулаа. Нэг дэх асуудал. Тэр болбол эхэн дээр нь тавьчхаад бид нар бүх мэдээллийг авах тийм техникийн боломж байж байгаа юм.

Хоёр дахь асуудал сервер чинь бас гаднын хамааралтай байж байгаа байхгүй юу. Дата төвийг чинь гаднынхан барьж өгсөн. Долоодугаар үеийн серверүүд одоо энэ гаднын хөрөнгө оруулалттай, үүрэн телефон холбооны компаниудад байж байгаа, гаднын хамааралтай.

С.Бямбацогт: Гүйцээгээд саналаа хэлчихье ээ. Микрофоны цагийг сунгая.

Б.Энх-Амгалан: Дээр нь энэ шилэн кабель гээд дамжуулалтын дэд бүтцүүд чинь гаднын хамааралтай. Ийм байж байгаа юм шүү. Ийм нөхцөлд бид нар ингээд нэг тийм дэд бүтцээ өөрсдөө хийгээгүй байж баахан юмыг ингээд цахим болгох асуудлаа ингээд түрүүлж явах нь зөв үү, буруу юу? Бодох ёстой. 1 дэх асуудал.

2 дахь асуудал. Би та бүхэнд хэлье. Өдөрт 66,2 сая хандалт байгаа юм. Түүний 14,6 сая нь бол халдлага байгаа юм шүү. Тэгэхээр бид нар нөгөө firewall буюу хамгаалалтаа хэр хийж байгаа вэ гэдгээ бодох цаг болчихсон юм аа. Одоо эндээс интернетийн хэрэглээ нийт хүн амын чинь 73 хувьд байна. Бүгд интернет хэрэглэж байна. Тэгээд фэйсбүүк инстаграмд орж байна. Тэгээд үүнийг дахиад та нарын өгсөн мэдээлэл дээр харахаар хувийн мэдээллийг хуурэн мэхлэх замаар ашиглаж байна уу гэдэг ийм судалгаа авахад 18-35 насныхан 41 хувь, 46-ас дээш нь 42 хувьтайгаар ашиглаж байна аа гэж гарч байгаа юм. Мэдэгдэхгүйгээр хувийн мэдээллийг ашигладаг, боловсруулдаг, дамжуулдаг ийм одоо юм байна уу гэхэд 40 хувь нь тэгж байна аа гэж хариулж байгаа юм. Бусдад буруугаар ойлгогдох гадуурхагдах, ялгаварлан гадуурхах, доромжлох, гүтгэх шинжтэй мэдээллүүд гээд. Тэгэхээр дахиад ийм өндөр хувь гараад ирж байгаа юм. Гучин хэдэн хувьтай. Ийм нөхцөлд бид нар ингээд хүний хувийн эрх гээд юмнууд ярьж байгаа ийм үедээ одоо бид нар цаашаагаа нэг зүйлийг бас нэг анхаарахгүй бол болохгүй байгаа юм аа.

Одоо хүний хувийн нууц, эмзэг мэдээллүүдийг маш сайн хамгаалья гээд байж байна. Зөв. Энэ бол зөв. Гэхдээ бэлгийн чиг хандлага яриад ирэхээрээ та нар бодоорой доо. Энэ бол эмзэг мэдээлэл нь. Хэзээ ч хөдөлж болохгүй мэдээлэл гэчхээд тэр ижил хүйстнүүд чинь одоо айлын нялх хүүхдүүдийг авч жагсаад байна шүү дээ. Мөнгө төгрөг өгөөд байна шүү дээ. Тусдаа байр савтай байна шүү дээ. Гаднын санхүүжилттэй байна шүү дээ. Төрийн бус байгууллагатай байна шүү дээ. Наргидаг, цэнгэдэг газраа бэлдээд байна шүү дээ. Ингэж болох юм уу? Монголчуудын хувьд. Үүнийгээ бас анхаарах ёстой.

Дээр нь Нийтийн мэдээллийн тухай хуулиар одоо ингээд бүх юмнууд нь ил болно оо гэж байна. Сэтгүүлчид болбол мэдээллийнхээ аюулгүй байдлыг хариуцна аа гэж байна. Тэгвэл бид нар тэр нүүрээ нуучихсан, нүдээ нуучихсан, нэрийг нь нуучихсан, утсаа нуучихсан тэр хүмүүс гарч ирээд үүнийг чинь ... /минут

дуусав/

С.Бямбацогт: 1 минут. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Яах вэ, хувийн хариуцлага нь сайжирдаг юм байжээ. Гүтгэж байгаа нөхдүүд ээ яах вэ, одоо танигдахгүй ингээд л ерөөсөө энэ нөхөр ингээд лицензтэй юм байна, тэгсэн чинь үүний ард ах нь байгаа юм байна, тэр нь байгаа юм байна, энэ нь байгаа юм байна гээд л, зүгээр л үлгэр зохиогоод л гүтгээд байгаа тэр нөгөө нөхдүүдээ яах вэ? Нэр, хаяггүй, утас нь тодорхой биш, нүүрэн дээрээ өөр зураг тавьчихсан. Тэгээд энэ чинь нөгөө аюулгүй байдлаа хамгаалж байгаа юм чинь ингээд байхгүй болчхож байгаа байхгүй юу. Ихэнх нь ийм. Түүнээс яг өөрийнхөө зургийг тавьж байгаа хүн, гүтгэж байгаа хүн бол бараг байхгүй, яагаад гэвэл хууль нь чангарчихсан учраас тэгж чадахгүй. Энэ хуурамч хаягуудаа яах юм бэ гэдгийгээ бас сайн бodoхгүй болбол бид нар нэг их мундаг хамгаалаад байдаг. Цаана нь хаалгыг нээгээд өгчхөж байгаа байхгүй юу. Хүн гүтгэх боломжийг нь. Үүнийг л анхаарах хэрэгтэй.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ Эрүүгийн хуулийн 13.11-ийг өөрчлөн найруулах санал оруулж ирсэн байгаа юм л даа. Тэгээд би нөгөө ажлын хэсгийн гишүүн биш учраас энэ өөрчлөн найруулалтыг хийхэд энэ шүүх, цагдаа, прокурорынхон оролцсон уу? Би яагаад ингэж асуугаад байгаа юм гэхээр энэ шүүгч нар байна шүү дээ. Энэ одоогийн байгаа 13.11-ийг хэрэглэхэд 2, 3 хүндрэлтэй асуудал байдаг гээд яриад байхгүй юу.

Нэгдүгээрт байна шүү дээ. Энэ олж мэдсэн хүн гэж байгаа юм. Олж мэдэх чинь аягүй олон төрлөөр олж мэднэ шүү дээ, тийм үү. Хайж байгаад, ухаж байгаад олох, эсвэл хэвлэл мэдээлэл дээр гарчихсан юмыг одоо юу гэдэг юм, Мөнх-Оргилын тухай нэг юм гарчихсан байхад нь өө, Мөнх-Оргилын тухай тийм юм гарч ирчхээд задруулах нэг асуудал, тэр нь хувийн нууцтай холбоотой асуудал байж болох байхгүй юу. Тэгэхээр энэ чинь нийтэд ил болчихсон мэдээллийг тараах нэг асуудал, нийтэд ил болоогүй нууц байгаа мэдээллийг олоод тараах нэг асуудал гээд энэ чинь аягүй зовлонтой юмнууд байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг нь уул нь нэг мөсөн янзлаад оруулж ирмээр байсан юм аа. Нууцыг олж мэдсэн гэж. Энэ чинь нөгөө нийтэд ил болоогүй мэдээллийг нууцад олж мэдсэн бол гэж ядаж нэг тийм тодорхойлолт баймаар. Тодруулга баймаар байхгүй юу.

Задруулсан бол гэдэг өөрөө бас их яг шүүх, прокурорынхон хэрэглэхэд их зовлонтой томьёолол болчоод байна гээд байгаа байхгүй юу. Яг юуг задруулсан юм хоёулаа ярьж сууж байгаад одоо Алтанхуяг аа, чи чиний тухай, чиний хажууд сууж байгаа Амараагийн тухай юм гарчихсан байна лээ гээд ярих нэг өөр. Тийм үү. Энэ чинь нийгэмд хүрэх нөгөө хохирол нь нэг. Гэтэл тэрийгээ одоо ингээд хэвлэл мэдээллээр тараачих нь нэг өөр, тийм ээ. Ингээд энэ задруулахыг бас нэг жоохон янзалж өгмөөр байгаа юм.

Гурав дахь асуулт. Энэ ялыг чангатгажээ. 450-5400 нэгж байсныг 1350-10000 нэгж болгож. Ингээд хорих ялыг ч гэсэн 6 сараас 2 жил хүртэл гээд ингээд янзалчхаж, чангалчхаж. Үүнийг яг энэ шүүгч, прокурор настайгаа зөвлөсөн үү? Яагаад гэвэл энэ Эрүүгийн хуулийн ялын бодлого чинь хоорондоо бүгд уялдаж явж байх ёстой шүү дээ. Гэнэт л нэг гэмт хэргийнх нь аймаар хүнд ялтай болчоод

л нөгөөдөх нь хуучнаараа үлдээд байж болдоггүй зовлонтой шүү дээ. Бид нар энэ одоо малын хулгайгаас эхлээд л үүнийг чинь олон янзаар янз янзаар л үзээд энэ эрүүгийн ял гэдэг чинь маш нарийн тооцож гаргаж тэр практик амьдрал дээр хэрэглэдэг хүмүүсийнх нь санал бодлыг тусгаж баймаар байгаа юм. Үүнийг нэг хариулаадхаач. Ингэж огцом чангалах ямар үр дагавар авчирна гэж бодож байна?

Энэ харилцаа холбоо тэгээд одоо байна шүү дээ. Энэ 13.11.2 дээр субъектүүдүг нь заачихсан байхгүй юу. Мэргэжлээр нь одоо нотариатч, бүртгэлийн ажилтан, төрийн албан хаагч гээд ингээд арван хэдэн субъектээр нь янзалчихсан. Гэтэл үүнийг ерөөсөө байхгүй болгоод зүгээр шууд албан үүргээ гүйцэтгэх явцад гээд биччихэж байгаа байхгүй юу. Тэгэхээр хуучин бол энэ гэмт хэргийн субъект чинь бол маш ойлгомжтой, тодорхой төрийн албан хаагчид буюу одоо одоо нотариатаас авахуулаад нөгөө үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс гээд ойлгомжтой байсныг албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн гэдэг чинь бүх төрлийн хүмүүс хамрах нь байна шүү дээ. Төрийн албан хаагчаас авахуулаад л одоо хувийн секторт ажиллаж байгаа танил, танил бүгдээрээ л орох нь байна шүү дээ. Тийм ээ. Энэ дээр.

Тав дахь асуулт. Энэ дээр Алтанхуяг гишүүний яриад байгаа миний нөгөө анхны хэлэлцүүлэг дээр яриад байсан юм бол албан үүргээ гүйцэтгэж явж байх дотроо гүйцэтгэх ажил хийж олж мэдсэн мэдээ материалыг тараах юм бол илүү ялтай баймаар санагдаад байгаа байхгүй юу. Тэр чинь төрийн маш нууц ажил хийж байна шүү дээ. Тэгтэл миний бүр тодорхой жишээ би яриад байсан биз дээ. Шөнө 12 цагт одоо нэг сэжигтнийд ороод нэгжлэг хийж байхад З цагт бичлэг нь фэйсбүүк дээр юм уу, твиттерээр гараад л явчхаж байгаа байхгүй юу. Тэрийг чинь хэн хийх юм, гэр орных нь зургийг нь аваад тавихгүй нь ойлгомжтой шүү дээ. Өөрсдөө санаатай тавьчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр ... /минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг Сайнзориг хариулья.

П.Сайнзориг: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулья аа. Ер нь бол өнөөдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу дүрсний бичлэг хийж дамжуулах, тараах, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах гэсэн энэ гэмт хэргүүд бол 2019, 2020 онд бол үндсэндээ цөөн тоогоор одоо бүртгэгдсэн байгаа. Жишээ нь, зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дамжуулах, тараах гэмт хэрэг бол 2019, 2020 онд бүртгэгдээгүй. 2021 оны 10 сарын байдлаар 1 бүртгэгдсэн. Хувь хүний нууцыг халдах гэмт хэрэг бол 2019 онд 14, 2020 онд 6, энэ оны 10 сарын байдлаар 4 байгаа. Хувь хүний нууцыг задруулах гэмт хэрэг 2019 онд 3, 2020 онд 2, энэ онд, бас 2 гээд. Ер нь бол энэ яах вэ, хүний хувийн мэдээлэл, хувийн нууцыг бас энэ хамгаалах задруулахдаа холбоотой төдийлөн одоо юу гэдэг юм соёлд бас дадаагүй байна аа л гэсэн ийм зүгээр юм харагдаад байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр бол маш их хэмжээний мэдээлэл задруулж байгаа боловч иргэд бас одоо юу гэдэг юм. Хууль сахиулах байгууллагад одоо өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалж бас хандаж байгаа байдлууд бас цөөхөн байгаад байгаа. Нэг талдаа энэ өөрөө бас нөгөө хуулийн тодорхойгүй орчин байгаа. Хувь хүн нууцаа өөрөө хамгааларай гэдэг 1995 оны хууль үйлчилж байгаа.

Хоёрдугаарт яг энэ хувь хүний нууцын ангиллыг зааж өгсөн болохоос биш яг ямар ямар мэдээллүүд нь энэ хөрөнгийн мэдээлэлд орж байгаа юм, ямар мэдээлэл нь эрүүл мэндийн мэдээлэлд орж байгаа юм, ямар мэдээлэл нь гэр бүлийн мэдээлэлд орж байгаа гэдэг зүйл нь бол хуулиар тодорхой нарийн

заагаагүй учраас энэ төрлийн гэмт хэргүүд бас шийдэгдэх асуудал жоохон хүндрэлтэй байгаа.

Ер нь бол эдгээр хуулиудыг боловсруулах явцдаа Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий проктор, мөрдөх чиглэлийн бүх байгууллагуудаасаа, төрийн бүх байгууллагуудаас санал авсан байгаа. Энэ дээр гэмт хэргийн шинж дээр тодорхой саналууд ирүүлээгүй байгаа. Тийм учраас бид нар энэ удаа гэмт хэргийн шинжийг таны хэлсэнчлэн бас хөндөж оруулж ирээгүй. Ял хариуцлагын бодлого дээр бол тодорхой өөрчлөлтүүд орж ирсэн. Улсын Их Хурал дээр бас тодорхой ял хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлийн дагуу хувь хүний нууцыг задруулах гэмт хэргийг бол ял хариуцлагыг хүндрүүлэх бүрэлдэхүүнээр нэмж өгч байгаа. Хүндрүүлэх бүрэлдэхүүн дээр нэмэгдэж байгаа нэг зүйл нь гэхээрээ харилцаа холбоо болон цахим орчинд буюу цахим сүлжээ ашиглаж хувь хүний нууцыг задруулж байгаа гэмт хэрэг дээр бол хүндрүүлэх бүрэлдэхүүний гэмт хэргийн шинж дээр нэмсэн.

Ер нь таны хэлж байгаа тэр албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэдэг зүйл нь хэвээрээ байгаа шүү. Энэ бол өнөөдрийн яг мөрдөж байгаа тэр томьёолол нь яг энэ хэвээрээ байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье. Ер нь зүгээр яах вэ, ял хариуцлагыг бас төдийлөн огцом нэмээгүй гэж ойлгож байгаа. Бусад төрлийн ижил төстэй гэмт хэргүүдэд оногдуулж байгаа, хувь нууцад халдах, төрийн нууцыг хууль бусаар олж авах ч гэдэг юм уу ийм гэмт хэргүүдтэй дүйцүүлж эдгээрийг харсан.

Ер нь зүгээр, цаашдаа бас Засгийн газраас оруулж ирж байгаа Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр энэ Гүйцэтгэх ажлын хууль тогтоомж зөрчих, мөрдөн мөшгөх, эрүү шүүлт тулгах ч гэдэг юм уу энэ чиглэлийн төрийн албан хаагчдын үйлдэж байгаа энэ гэмт хэргүүдийг ялын хариуцлагыг бас чангатгах бодлого барьж байгаа. Энэ дээр бол тодорхой холбогдох ажлын хэсэг ажиллаад тун удахгүй энэ ондоо багтаагаад бас Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өргөн барина аа. Энэ дээр бас тодорхой зарим төрлийн гэмт хэргүүдийг гүйцэтгэх ажлын хууль тогтоомж зөрчих ч гэдэг юм уу. Энэ төрлийн үйлдлүүд дээр ял хариуцлагыг нэмэгдүүлэх ийм бодлого барьж байгаа гэдэг зүйлийг бас танд мэдээллийг өгье.

С.Бямбацогт: Баярлалаа. Ерөнхийдөө бол гүйцэтгэх ажилтай холбоотой сая яригдаж байгаа асуудлуудаар нэлээн ялын бодлого чангараах нь байна гэж ойлголоо.

Учрал ажлын хэсгийн ахлагч нэмж хариулъя.

Н.Учрал: Анхны хэлэлцүүлгийн үеэр Мөнх-Оргил гишүүн болон бусад гишүүд ялын бодлого дээр саналуудыг хэлсэн. Тэгэхээр бид бол албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээллээ ерөнхий байдлаар нь хуульчлаад яг тэр тодорхой байгууллагуудыг зааж өгөхгүйгээр ямар ч тохиолдолд албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээллийг хувь хүний нууцыг нь тэр олж авсан мэдээлэл хариуцаж хамгаалах ёстой гэдэг утгаар нь ерөнхий байдлаар нь хуульчлах нь зөв гэж үзсэн. Тэр гүйцэтгэх ажлын асуудал дээр бол анхны хэлэлцүүлэг дээр санал хураасны дагуу гүйцэтгэх ажлын хуулиар тусгайлсан зохицуулсан гээд тодорхойлолтыг аваад үзчихэж байгаа юм. Тэгэхээр тэр цуглувулж, боловсруулж, ашиглаж байх явцдаа олж авсан мэдээлэл биш гүйцэтгэх ажлын хуулиар тусгайлсан зохицуулсан харилцаан дээр гээд тодорхойлж өгсөн

гэдгийг хэлмээр байна.

Түрүүн бас Энх-Амгалан гишүүний асуултад хариулахад бид бас нэг зүйлийг ойлгох ёстой. Яг тэр манай төрийн мэдээллүүдийг төрийн үйлчилгээг явуулж байгаа хур систем гээд байгаа иргэдийн мэдээллийг цуглуулж байгаа тэр үндсэн сервер бол Монголдоо л байгаа. Тэр гадаадад байршаад байгаа зүйл ерөөсөө байхгүй. Тэр Үндэсний дата төвийн мэдээллүүд бол. Тэгэхээр интернет, хийсэн нь хамаагүй, үндсэн сервер Монголд байгаа. Дээрээс нь интернет бол зөвхөн шилэн кабель бол биш шүү дээ. Цаанаа интернетийн томоохон агуулга мэдээллүүдийг нь агуулж байгаа шүү дээ. Тэгэхээр Монгол Улсад явж байгаа энэ шилэн кабель чинь өөр бусад улсуудтай мэдээллүүдийг солилцож байгаа тэр урсгалыг л хийж байгаа. Тийм учраас яг тийм шууд утгаараа тайлбарлах бол бас бололцоогүй ээ. Гэхдээ бид нар энэ Нийтийн мэдээллийн хуулиар үндсэн систем, суурь болон дэмжих систем Монгол Улсын нутаг дэвсгэрт байршина аа гээд ингэж зааж өгсөн.

Энх-Амгалан гишүүн ээ. Энэ Нийтийн мэдээллийн хууль дээр энэ мэдээллийн системүүд Монгол Улсад байршуулна гээд бас зааж өгсөн. Өмнө нь бол ерөөсөө заагаагүй юм байна лээ. Тэгэхээр энэ хууль дээрээ ингэж тодорхой зааж өгсөн. Тэгээд бид бүгдээрээ мэдэж байгаа. 2 хөршөөс манай улс бол хамааралтай. Гэхдээ одоо сансрын хиймэл дагуулын асуудлыг хүртэл бид нар олон жил ярилаа. Үнэхээр бас хараат бусаар оршин тогтоно гэвэл цаашдаа энэ сансрын хиймэл дагуулын асуудлыг бас ярих ёстой. Ийм цаг үе мөн. Гэхдээ хууль, эрх зүйн орчноо ядаж ингээд дэвшил гаргаад хийгээд өгөх юм бол бид үндсэн концепцоо бас бариад цаашдаа ч гэсэн ажиллахад дөхөм болох болов уу гэж бодож байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо Доржханд гишүүн асуултаа асууя.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр энэ багц хуулийн төслүүд, ажлын хэсэгт ажиллаж байгаа. Энэ төслүүд батлагдсанаар бол Монголд нэлзэн дэвшил гарна аа гэдэг итгэл үнэмшил байгаа. Ялангуяа хувь хүний мэдээлэл, цахим гарын үсэг, Кибер аюулгүй байдал дээр бол яалт ч байхгүй бид нар өнөөдөр зохицуулах шаардлагатай байгаа. Тэгээд энэ дээр их олон тийм хүлээлтүүд байна. Хувийн секторт хөрөнгө оруулагч нарын хувьд бол. Тийм болохоор энэ бол маш яаралтай батлагдаад явах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа. Нэгэнт энэ Хууль зүйн яамныхан ирсэн байна. Тэгээд тагнуулын байгууллагынхан ирсэн байна. Энэ тохиолдлыг ашиглаад 1 зүйл тодруулчихмаар байгаа юм.

Энэ Богд зонхов гэж энэ асуудал гарч ирлээ. Тэгээд төсвийн асуудал ярьж байхад бол маш олон болохгүй бүтэхгүй байгаа асуудлуудыг ярьдаг. Харин үүнийг иргэд өөрсдөө гаргаад ирлээ. Энэ асуудлыг. Цаашдаа ч гэсэн энэ явах юм шиг байна аа. Энэ дээр харин нэг ноцтой асуудал байна. Өчигдөр Сангийн сайд ноцтой мэдэгдэл хийсэн. Тэр нь юу вэ гэхээр Богд зонховын барилгыг барих тендер зарлаагүй байхад бүтээн байгуулалтаяа хэн ч юм эхлүүлчихсэн байна аа. Төсөвт өртөг 27 тэрбумаар өссөн гээд. Тендерийн тухай хууль дээр төсөв батлагдсан байх ёстой. Тэгээд 2 дугаарт гэрээ байгуулагдсан байх ёстой. Мөн биз. Тендер шалгаруулаад. Тэгж байж ажил нь эхлэх ёстой байхад нэг хүн тэнд өөрийнхөө хөрөнгөөр талбай дээр шавар зуурчихсан. Тэгээд тэрийг одоо хайгаад олдоггүй. Тэгээд одоо өнөөдөр иргэд асуугаад байна л даа. Та Улсын Их Хурлын гишүүний хувьд энэ асуудлыг тодруулаач ээ гээд. Холбогдох хуулийн байгууллагуудад нь асуугаач ээ. Энэ дээр тогтоогдсон хүн байна уу, үгүй байна уу.

Энэ чинь цэвэр төсвийн хулгай шүү дээ. Тэгээд энэ чинь бол та бүгдийн хийж байх ёстой, анхаарч байх ёстой ажил. Бас энэ хуулийн төслүүдийн зорилго нь бас ийм мэдээллүүдийг олж аваад, мэдээлэл гаргаж байгаа хүнийг нь хамгаалаад хуулийн хариуцлага тооцох ёстой гэсэн ийм итгэл үнэмшлээр энэ хуулийг бас дэмжээд ажлын хэсэгт нь ажиллаж байгаа.

Тэгэхээр асуулт нь юу байна вэ гэхээр энэ чиглэлээр судалгаа хийж байгаа, шалгаж байгаа хуулийн байгууллагаас чиглэл өгөгдсөн ажил хийж байгаа зүйл байна уу. Төрийн нарийн бичгийн дарга аа. Баасандорж дарга аа. Тагнуулынхан. Энэ чиглэлээр ажил хийгдэх үү. Цаашдаа ийм төсвийн хулгайнууд дээр та бүгд анхаарч ажиллах юм уу. Энэ чинь бол авах нь тодорхой гээд тэнд 1 хүн бүр ингээд маш ихэмсэг байдлаар ингээд өөрийнхөө мөнгөөр тэр талбай дээр маш том байгууламж барьчихсан явж байна шүү дээ. Тэр эрхийг чинь хаанаас авах уу. Газрын эрхийг чинь тухайлбал нийслэлээс авах ёстой шүү дээ. Зүгээр ингээд Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр өөрсдийнхөө тойрог дээр ажлаа хийе ээ гэхээр газар олдлоггүй шүү дээ. Гэтэл тийм талбай дээр ингээд барилгаа барьчихсан. Эрхээ авчихсан. Тэгээд улсын төсөвт суулгах гээд. Тэрийг ингээд төсвөө 1 өдөр 27 тэрбууаар өсгөчихсөн. Тэрийг нь Их Хурлын гишүүд нь ч мэддэггүй, Засгийн газрын гишүүд нь ч мэддэггүй. Бие бие рүүгээ чихээд байдаг. Ийм байдлаар одоо хариуцлага тооцох ёстой байх аа. Тийм болохоор энэ дээр тодорхой хариулт өгмөөр байна. Их Хурлын гишүүний хувьд би үүнийг та бүгдэд шаардах одоо холбогдох хянан шалгах үйл ажиллагаа явуулаач ээ гэсэн ийм шаардлагыг хүргүүлэх болно шүү. Баярлалаа.

С.Бямбацогт: Хэлэлцэх асуудалтай огт холбоогүй асуудал. Гэхдээ бас нийгэмд анхаарал татсан олны шүүмжлэл дагуулсан ийм асуудал байна аа. Тийм болохоор хэдийгээр хэлэлцэх асуудалтай огт холбоогүй. Бид нар Их Хурлын гишүүд бас хэлэлцэх асуудалтай холбоотой юм ярьж байх ёстой шүү.

Гэхдээ холбоогүй ч гэсэн бас хариулчихъя даа. Баасандорж дарга аа.
Хууль зүй, дотоод хэргийн яам Баасандорж, Доржханд гишүүний асуултад хариульяа.

Ер нь 2012 оны төсвийн тухай хууль байдаг. Төсвийн тухай хуулиар төсвийг зохиох, боловсруулах, Засгийн газраар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх журмыг бүр нарийвчлан заасан байдаг. Улсын Их Хуралд Засгийн газраас төсвийг 10 сарын 01-ний дотор өргөн мэдүүлэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар бүр тусгай дэгээр. 4 хэлэлцүүлэгтэй. Төсвийн хуулийг хэлэлцэж баталдаг. Тэгэхээр төсөв бол өөрөө онцлогтой. Тусдаа дэгээр явдаг. Бусад хууль тогтоомжоос яг тусгайлсан дэгээр зохицуулагддаг ийм асуудал байгаа.

Би таны саяын үндсэн асуудал дээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ямар нэгэн тийм асуудал бол чиглэл өгдөггүй. Хуулийн байгууллагад, цагдаагийн байгууллага дээр. Чиглэл өгдөг эрх хэмжээ бол манай яаманд байхгүй. Гэхдээ би таны хөндөж тавьсан энэ Хууль зүйн байнгын хороо дээр яригдсан асуудал учраас Цагдаагийн ерөнхий газраасаа холбогдох хууль тогтоомжийнхоо дагуу би мэдээллийг уламжлаад тэгээд танд танилцуульяа.

С.Бямбацогт: Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явуулна аа, гишүүд ээ.

2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны үеэр Улсын Их Хурлын даргын өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу болон ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуульяа.

1. Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу хураалгах саналууд.

1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг” гэснийг “биометрик мэдээллийг” гэж өөрчилж, 10.1.4 дэх заалтын “эрүү, иргэн, захиргааны болон бусад” гэснийг, 10.2 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон” гэснийг тус тус хасаж, 10.2 дахь хэсгийн “ажилтны” гэсний дараа “зөвшөөрлөөр” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.5.Улсын Их Хурлын гишүүнийг хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор биометрик мэдээллийг.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуульяа.

63,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

2 санал байгаа.

1 дүгээрт нь Төслийн 1 дүгээр зүйлийн “караоке” гэснийг “караокены өрөө” гэж өөрчилж, мөн зүйлийн “цахилгаан шат” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

63,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2, 3 дугаар зүйл болгох:

“2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 13.11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

13.11 дүгээр зүйл.Хувь хүний нууцыг задруулах

1.Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.харилцаа холбоо, цахим сүлжээ ашиглаж;

2.2.Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Эрх бүхий албан тушаалтан” гэснийг “Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, бусдад дамжуулсан, эсхүл эрх бүхий албан тушаалтан” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

63,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураах саналууд.

1. Төслийн 18 дугаар зүйлийн 18.2.11 дэх заалтын “мэдээллийн эзний” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт явуулья. Санал хураалт.

61,9 хувь гэдэг чинь гуравны хоёрт хүрэхгүй байна аа. Хүрэхгүй бол хүрэхгүй тийм.

Ингээд энэ санал дэмжигдсэнгүй ээ.

Санал хураалтыг явуулж дууслаа. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Учрал гишүүн, ажлын хэсгийн ахлагч танилцуулна аа.

Дараагийн асуудалдаа оръё.